

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

2021/06/10

Д/д	Байгууллагын нэр	Алдаа, зөрчил			Барагдуулах эцсийн хугацаа	Хэрэгжилтийн байдал			Хэрэгжилтийн	Хариуцсан аудитор		Тайлбар өгөх /Акт тавигдсан шалтгаан, хэрэгжүүлэх арга зам/	
		Утга	Акт, албан шаардлагын огноо, дугаар	Дүн /сая.төг/		Барагдуулсан		Зөрүү /- дутуу/, /+илүү/		ҮАГ-ын давтан хяналт ар	Тогтоосон		Хянасан
						Баримтын огноо, дугаар	Дүн /мян.төг/						
1		Өмнөх оны аудитаар бэлтгэн нийлүүлэгчээс авах 433.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоосныг компанийн хөрөнгөөс барагдуулж, бэлтгэн нийлүүлэгч компаниудаас авлагыг цуглуулаагүй байна.	2021/03/15-ны өдрийн №322/А017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ		2021/06/10							Монгол-Уураг ХХК, Үлэмж трейд ХХК, ЭХБУТрест ХХК, Алтантэнгэр дэлгүүр, Хангайн зам ХХК, Геомандал степпе ХХК, Эй Ди Ди ХХК, Их монгол медиа ХХК, Сэконс ХХК, Тулга тайш ХХК, Нью сүрьеэ ХХК, Мэдрүүр ХХК нийт 13 байгууллагыг шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч 6 нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 7 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Иймд дахин шаардлагатай материалуудыг бүрдүүлэн шүүхэд нэхэмжлэл гаргахаар бэлтгэн ажиллаж байна.	
2		Бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой 7 харилцагчийн 62.8 сая төгрөгийн авлага, 85 харилцагчийн 3,691.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үүний 62.8 сая төгрөгийн авлага, 418.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл насжилт өндөртэй байна.	2021/03/15-ны өдрийн №321/А017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ	3,754.0	2021/06/10							Бэлтгэн нийлүүлэгчийн өглөгийн тооцоо нийлэх дээд хязгаарыг НББ-ийн бодлогын баримт бичигт шинэчлэн оруулах хувилбарыг Захирлын зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Өглөгийн тооцоо нийлээгүй гэх дээрх дүнгээс 2,778.9 сая төгрөгт тооцоо нийлж 1,117.1 сая төгрөгийн тооцоог цар тахлын нөхцөл байдлын улмаас нийлж чадаагүй байна.	

3	<p>Өмнөх онд 69.0 сая төгрөгийн 10 ширхэг шугамын гэмтэл заагчийг худалдан авсан боловч уг программ нь шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй бараа материал хүлээн авсан байна.</p>	<p>2021/03/15-ны өдрийн №323/А017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ</p>	69.0	2021/06/10				
---	--	---	------	------------	--	--	--	--

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зүгээс “Тендерийн нөхцлийн дагуу бараа нийлүүлсэн боловч гэрээ дүгнэх үед тус барааг програмтай холбож өгөх үйлчилгээ мөн багтсан гэж Диспетчерийн албаны инженер хэлснээр асуудал үүссэн” гэсэн тайлбар өгсөн байна. Мөн хэрвээ тус тендерийн үнэлгээнд үйлчилгээ үзүүлэх хөлс багтсан байсан бол түүнийгээ дурдах ёстой байсан гэж үзжээ. /Гэрээ, протокол хавсаргах/

Нийлүүлэгч компани диспетчерийн албаны СКАДА систем хариуцсан инженертэй олон удаа уулзаж ярилцаад холбох талаар ярилцсан байна. Ойрын хугацаанд шийдвэр гаргана гэсэн хариу ирүүлсэн болно. Хангамж үйлчилгээний албаны зүгээс нийлүүлсэн гэмтэл заагчаа холбож ажиллуулах боломжгүй бол авч явах талаар мэдэгдсэн байгаа.

4	УБЦТС ТӨХК	Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх 51,747 метр квадрат 14 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй, мөн 810 ширхэг цахилгааны барилга байгууламжид хамаарах газрын кадастрын зургийг хийлгэсэн боловч газрын гэрчилгээг гаргуулан аваагүй	2021/03/15-ны өдрийн №324/А017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ	0.0	2021/06/10					Э.Энх цэцэг	Г.Түвш инзаяа	Газар эзэмшихтэй холбоотой бүртгэлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн газрын албанд 826 газрын давхацлыг шалгуулж байна, одоогоор хариу ирээгүй. Үүнээс гадна Төв аймгийн 58 газрын эзэмших эрхийн давхацлыг шалгуулахаар хандаж 31 газрын эзэмшил давхцаагүй, 27 газрын эзэмшил давхцсан гэсэн хариу ирсэн. Давхцсан газрын асуудлаар газрын тус аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран ажиллаж мэргэжлийн зөвлөгөө авахаар албан бичиг хүргүүлсэн. /Ирсэн явсан бичиг хавсаргах/ Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан 13 газар байна. Газрын гэрчилгээний хугацаа сунгуулахаар 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр НГА-нд хандсан НГА-аас газрын гэрчилгээний хугацаа сунгуулахад газрын хянан баталгаа болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх гэсэн шаардлага тавьсан тул тусгай зөвшөөрлийн эрх бүхий компаниудыг судалж 05 дугаар сарын 18-ны өдөр хэд хэдэн компанид мэдээллийг хүргүүлж үнийн санал ирүүлэхийг утсаар болон мэйлээр мэдэгдсэн болно. Үүний дагуу 05 дугаар сарын 20-ний өдөр Эх монголын байгаль ХХК /15,350,000₮/, Газар дэлхий ХХК /18,500,000₮/-аас тус тус үнийн санал ирүүлснийг ахлах мэргэжилтэн, СБХ-ийн дарга болон Нийтлэг үйл ажиллагаа эрхэлсэн дэд захиралд тус тус танилцуулж илтгэх хуудас бичиж Гүйцэтгэх захирлаас гэрээ байгуулах болон тухайн төсөв мөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар зохих зөвшөөрлийг 05 дугаар сарын 31-ний өдөр авсан. НБОГ-ын холбогдох мэргэжилтэн /Жаргалсайхан/-тэй утсаар ярьж тодруулахад тухайн газрын зориулалт, байршил, дэд станцын хүчин чадал зэрэг мэдээллийг бэлтгэн ирж уулзах түүний дараа газрын хянан баталгаа болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай гэсэн тул ТБЗХ-ээс холбогдох мэдээллийг авч танилцуулга бэлтгэсэн. 06 дугаар сарын 10-ны өдөр НБОГ-ын Жаргалсайхантай уулзахаар тохиролцсон байсан боловч ойрын хавьтал болсон тул уулзах хугацаагаа хойшлуулаад байгаа болно.
---	---------------	---	--	-----	------------	--	--	--	--	----------------	------------------	--

5		<p>“Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн оффис бүхий ажилтнуудын орон сууц”-ны төслийн үндсэн зорилгыг хангахгүйгээр нэр бүхий 3 ажилтанд тус бүр 2 орон сууц борлуулсан, мөн тавигдах шаардлагад нийцээгүй 1 ажилтанд орон сууцыг худалдсан зэрэг тэгш, хүртээмжтэй хувиарлаагүй байна.</p>	2021/03/15-ны өдрийн №325/A017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ	0.0	2021/06/10				
6		<p>Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 241 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 15,061.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй</p>	2021/03/15-ны өдрийн №327/A017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ	15,061.2	2021/06/10				

<p>УБЦТС ТӨХК нь ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд ажилтнуудаа ая тухатай ажиллах амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор орон сууцанд хамруулах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Чингэлтэй ХҮТ-ийн оффисын байр болон ажилчдын орон сууц нь мөн адил “Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн оффис бүхий ажилтнуудын орон сууц”-ны төсөл нэртэйгээр хэрэгжсэн. Төслийг хэрэгжүүлэхдээ 2019 онд Гүйцэтгэх захирлын А/11 дүгээр тушаалаар төсөлд хамрагдах ажилтнуудыг шалгаруулах журмыг баталсан. Энэ журмыг бүх нэгжид хүргүүлэн ажилтнуудад өөрийн дотоод сүлжээ АВЛЕ программын олон нийтийн талбарт байршуулан танилцуулсан. /ГЗ-ын 2019 оны А/11 дүгээр тушаалыг хавсаргав./</p> <p>Нэгжүүдээс тухайн төсөлд хамрагдах хүсэлтэй ажилтнууд хүсэлтээ ирүүлж байрны сонголтоо нээлттэйгээр хийж “Орон сууц худалдан авах нөхцөлтэй захиалгын гэрээ” байгуулсан. Тухайн байрнаас сонголт хийгдээгүй байрнууд үлдсэн тул компанийн дотоод сүлжээ АВЛЕ программын олон нийтийн талбарт дахин “ЧХҮТ-ийн оффис, ажилтнуудын орон сууцны 3-16 давхарын төлөвлөлт”-ийг танилцуулж “ЧХҮТ-ийн оффис, ажилтнуудын орон сууцны нэмэлт захиалгын мэдээлэл”-ийг удаа дараа байршуулж тухайн байрнаас байр худалдан авах боломжтой байгааг ажилтнуудад нээлттэй зарлаж ажилнууддаа зарж борлуулсан.</p> <p>Иймээс худалдан авах хүсэлтэй олон хүн хүсэлт гаргасан байхад бүх ажилтанд хүртээмжтэй хуваарилаагүй байгаа зөрчил үүсээгүй бөгөөд хэн нэгэн ажилтнаас ямар нэгэн гомдол ирээгүй болно.</p> <p>Цаашид ч ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч ил тод нээлттэй зарчмыг баримтлан тухай бүрд нь түр журам, төсөл боловсруулан хэрэгжүүлэн ажиллана.</p>
<p>2020 он хүртэл шилэн дансны цахим хуудсанд 5 сая-10 сая хүртэлх үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлж байсан бөгөөд аудитын зөвлөмжийн дагуу 2021 оны 1 сарын 01-нээс эхлэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бүх бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлж эхэлсэн.</p>

7	<p>Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 274.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээний хороо нь холбогдох хууль, журам боловсруулсан тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу үнэлгээг үнэн зөв хийгээгүйгээс шаардлага хангаагүй тендерийн материал ирүүлсэн оролцогчийг сонгон шалгаруулж, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавиагүй байна.</p> <p>Мөн нээлттэй тендер шалгаруулалтын журам мөрдөгдөх 214.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 147.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээг шууд худалдан авалтаар, харьцуулалтын аргаар сонгон</p>	2021/03/15-ны өдрийн №326/А017 07 САГ-2021/33 СТА-ТӨҮГ	736.7	2021/06/10												<p>Тухайн оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төлөвлөлт эдийн засгийн хэлтэсээс батлуулан Нээлттэй тендер харьцуулалт, шууд худалдан авалт зэргийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарладаг болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12-р зүйлийн 12.1 т заасний дагуу тендер оролцогчийг тэгш боломжоор хангах өрсөлдөөнийг дэмжих үүднээс энэ хүү хуулийн 14-16 зүйлд заасны дагуу тендерийн баримт бичиг боловсруулж үнэлгээ хийгдсэн байна. "Алтан ундрага трейд" ХХК-г сонгон шалгаруулахдаа хуулийн 16.1.6 16.1.7 мөн 15-р зүйлийн санхүүгийн чадварийг хуульд заасан бусад нөхцөлөөр бүрэн хангаж байсан.</p> <p>Дотоодын үйлдвэрлэлийн бараа :Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 зүйлд заасны дагуу тендерийн баримт бичиг боловсруулж үнэлгээ хийсэн. Мөн хуулийн 14 дүгээр зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаж байсан. Дотоодын үйлдвэрлэлийн бараа (мах, махан бүтээглэхүүн) нийлүүлэхээр 2 компани материал ирүүлсэн тухайн үед тендер амжилтгүй болвол ажилчдын цайны газар ажилчдад хоол хийх махгүй, цайны газрын үйл ажиллагаа зогсох хүртэл эрсдэлтэй байсан. Дээрх нөхцөл байдлаас үүдэн тендер дахин зарлах хугацаа байхгүйг үнэлгээний хороо бодолцон үзэж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14 дүгээр зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаж байна гэж үзэн шийдвэрлэсэн.</p> <p>- Нийтийн эзэмшлийн зам талбай нөхөн сэргээх ажлын тендер эхний удаа оролцогч ирээгүй 2 дахь удаад 1 оролцогч ирсэн бөгөөд нөхөн сэргээх ажлууд маш их байсан, нөхөн сэргээгдээгүй байгаа талбайд явган зорчигч гэмтэх, хөдөлгөөний саатал үүсэх гэх мэт эрсдэл ихтэй, нийслэлийн захирагчийн ажлын албанаас удаа дараа шаардлага ирж байсан, Эвт өндөр ХХК нь тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч өмнө хийж байсан туршлагатай зэргийг тооцон шалгаруулсан. □</p>
			19,620.9													

Биелэлт гаргасан

Д.Төгсжаргалан